

ЧИНГИС ХААНЫ ТӨРИЙН ҮЗЭЛ, СЭТГЭЛГЭЭ

Л. Идэр
Доктор (Ph.D)

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн ахисан түвшний сургууль

Lozvoiiider88@gmail.com

Хураангуй: Чингис хаан арга мэхтэй, биеэ барих тэвчээр сайтай, эрс шуурхай, зориг шийдвэртэй, бат журмыг хүндэтгэдэг эр болон өсч байсан [1] бөгөөд багаасаа улс төрийн үйл явдлуудтай учирч эцэг Есүхэйн бодлогыг үргэлжлүүлэх цааш хэрхэн улс орноо авч явах тал дээр анхаарал хандуулж иржээ. Тэмүүжин тогтвортой төр засаглалыг бэхжүүлэхийн тулд олон арга, тактик хэрэглэж өөрийн нөлөөг тогтоохыг эрмэлзэх болсон. Түүний нэг нь өөрийн хүрээлэл нөлөөг бий болгох нөхцөл боломжуудыг ашиглаж байсан нь түүхээс тодорхой харагддаг. Мөн өөрийн хүч чадлаар олон бүлэг хүмүүсийг хүчээр дагуулан авав. Бас бус аймгуудын эрх баригчдад нухлагдан дарлагдсан хүмүүсээс мөн Тэмүүжинг шүтэж, даган амьдрахаар ирэх болов. Чухам энэ үеэс Тэмүүжин өөрийг нь тойрон хүрээлж ирсэн найдвартай нөхөд, анд нарын тусламжтайгаар “хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа бөөгнөрүүлэхийг” [2] эрмэлзэх болжээ. Эндээс анд нөхөрлөл, бусдын хүчээ нөлөө чухал болохыг мэдэрч бүрэн дүүрэн зохион байгуулж байсан байдаг.

Түлхүүр үгс: Төрт ёс, Уламжлал, Чингис хаан, төрийн үзэл, сэтгэлгээ, анд нөхөрлөл

УДИРТГАЛ

Чингис хаан арга мэхтэй, биеэ барих тэвчээр сайтай, эрс шуурхай, зориг шийдвэртэй, бат журмыг хүндэтгэдэг эр болон өсч байсан [3] бөгөөд багаасаа улс төрийн үйл явдлуудтай учирч эцэг Есүхэйн бодлогыг үргэлжлүүлэх цааш хэрхэн улс орноо авч явах тал дээр анхаарал хандуулж иржээ. Тэмүүжин тогтвортой төр засаглалыг бэхжүүлэхийн тулд олон арга, тактик хэрэглэж өөрийн нөлөөг тогтоохыг эрмэлзэх болсон. Түүний нэг нь өөрийн хүрээлэл нөлөөг бий болгох нөхцөл боломжуудыг ашиглаж байсан нь түүхээс тодорхой харагддаг. Мөн өөрийн хүч чадлаар олон бүлэг хүмүүсийг хүчээр дагуулан авав. Бас бус аймгуудын эрх баригчдад нухлагдан дарлагдсан хүмүүсээс мөн Тэмүүжинг шүтэж, даган амьдрахаар ирэх болов. Чухам энэ үеэс Тэмүүжин өөрийг нь тойрон хүрээлж ирсэн найдвартай нөхөд, анд нарын тусламжтайгаар “хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа бөөгнөрүүлэхийг” [4] эрмэлзэх болжээ. Эндээс анд нөхөрлөл, бусдын хүчээ нөлөө чухал болохыг мэдэрч бүрэн дүүрэн зохион байгуулж байсан байдаг.

Цэрэг эрс өөрийн нөхдийг бэхжүүлж, зохион байгуулах явдал бол Монголчуудын эзэн хаадын хамгийн чухал үйлс байв. Тэмүүжин тухайн үеийн

нийгэм дэх авъяас билигтэй, хамгийн идэвхтэй, хамгийн чухал хүчин болох нөхдийг ашиглан зорилгодоо хүрсэн ажээ.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Нөхөд гэдэг бол хаандаа жинхэнэ ёсоор үйлчлэх үүрэгтэй чөлөөт байлдагч юм. Жинхэнэ нөхөр болохын тулд андгай тангараг тавина. Нөхөд нь ямар нэг хэрэг явдлыг хамаарч эзэндээ үйлчлэх ба бас хааныхаа хамгийн дотно туслагч, зөвлөгч болно. Энэ үеийн Монголын баатар, тайж, ноён, хан зэрэг нь тэднийг хамгаалж, тэдний хишигтэн болж байжээ. Нөхрийн шалгуур нь хаандаа үнэнч байх явдлаар илэрч байсан байна. Хамт дутааж явсан ноёноо хээр орхиод дагаар орохоор ирсэн нэгэн ардыг Чингис: хаан эзнээ хаяж ирсэн хүн хараахан итгэж болохгүй хүн гэж цаазалжээ. Гэтэл өөр нэг хүн баригдаж ирэхэд: өөрийн эзнийг орхихгүй, түүний амийг аврахын төлөө байлдсан эрийг хэн буруушаах вэ нөхөрлөж болох хүн байна [5] хэмээн өөрөө авчээ. Энэ бүхэн нь нөхөр бологч хүн эрх биш эзэндээ шударгыг гүйцэтгэх ёстой гэсэн ойлголтыг төрүүлж байсан байна.

Тэмүүжин дөрвөн сайн нохойтой [5] хэмээн “Монголын нууц товчоонд” өгүүлжээ. Энэ нь Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй дөрвөн баатарыг хэлж буй хэрэг болно. Тэгэхдээ тэднийг нохой хэмээн ямар нэг араатан амьтан гэдэг утгаар биш, харин эзэндээ үнэнч шударга бат итгэлтэй зүтгэдэг гэдэг утгаар өгүүлж, бахархал болгон хэлжээ. Өөрийн эзэнд үнэнч болбоос юунаас ч эрхэм гэж Тэмүүжин өөрөө үздэг байжээ. Анд боллоцох ёс нь тулгуур төр байгуулагдахын өмнө Монголын төрт ёсонд байсан бөгөөд Тэмүүжин түүнийг өрсөлдөгчөө цохин улс байгуулах хэрэгт ихээхэн амжилттай ашиглажээ. Нөхөр ёсны харилцааны илэрхийлэл болж байсан анд анд боллоцох ёс төр хаадын улс төр-цэргийн холбоо эвслийн шинж чанартай болж иржээ. Анд боллоцох хоёр этгээдийн тангараг нь тэдний хоорондын нэг ёсны ам гэрээ байв. Тангараг өргөхдөө хоёр этгээд хүч хавсран дайсантай тэмцэх, бие биедээ үнэнч шударга байх, харилцан эрх мэдэл тэгш байх, хэрүүл маргааныг нүүр учран хэлэлцэж учрыг олж байх зэрэг зүйлийг хэлэлцэн тохиролцдог журамтай бай [6] жээ. Тэмүүжин зорилгодоо хүрэхийн тулд эцгийн анд явсан Хэрэйдийн тан Тоорилыг түшиглэх болсон байна. мөн багын анд жадран овгийн Жамухатай харилцаа тогтоожээ. Жамуха бол тэр үеийн Монгол аймгийн ноёдын дотор ихээхэн нөлөөтэй байжээ. Тэмүүжин, Тоорил, Жамуха гурав хүч нэгдэж, их бага аймаг, ханлигуудыг довтлон байр сууриа бэхжүүлэх боломжтой болжээ. Тэд эхлээд 1185 онд Гурван мэргидийг хиар цохиж, хүн амыг хуваан авч, урьд олзлогдсон Бөртэ хатан ба бусад харъяатуудаа чөлөөлжээ. Энэ үеэс Тэмүүжин хүчтэй болж, засгийн эрхийн төлөө өрсөлдөн амжилтанд хүрчээ.

1189 онд Монголын гол ноёд Тэмүүжинг Хамаг Монголын хаанд өргөмжилжээ. Тэмүүжин 1185-1206 оны хооронд их бага гучин хоёр удаагийн дотоодыг дайныг өнгөрүүлж, Монгол угсааны нийт наян нэгэн аймгийг нэгтгэн төвхнүүлжээ. Тэмүүжиний үед бүх Монгол аймаг ханлигийг нэгтгэн нэгдсэн улсыг байгуулагджээ. [7] Монгол аймаг, ханлигуудыг нэгтгэх чиглэлээр явуулсан Тэмүүжингийн үйл ажиллагааны амжилт нь хүчирхэг нөхөд, андуудаар өөрийгөө хүрээлүүлэн тэднийг чадамгай зохион байгуулж, тууштай цэрэг эр болгон хүмүүжүүлэн дайчилсанд оршино. Мөн харц ардууд, үнэнч баатарлаг хүмүүсийг олж өөртөө хүчин зүтгүүлсэн хийгээд Монгол аймаг, ханлигуудын дэмжлэгийг авч чадсанд оршино. Тэмүүжин авьяас чадвараараа товойн гарсан цэргийн том жанжин, төрийн болон улс төрийн томоохон зүтгэлтэн байв. Онон мөрний эхэнд их хуралдаан зарлан хуралдуулав. 1206 онд болсон Монгол ноёдын тэрхүү чуулганаар Монголын нэгдсэн тулгар улсыг албан ёсоор байгуулж, Тэмүүжинг эзэн хаанд сүр жавхлантайгаар өргөмжилж, түүнд Чингис хаан цол өргөж, есөн хөлт цагаан тугийг ёс төртэй мандуулжээ.

Монголын эзэнт улс нь өмнөх уламжлал дээр тулгуурласан хэмжээгүй эрхт хаант засаглалтай улс байлаа. Чингис хаан улсаа аравтын системээр зохион байгуулагдсан цэрэг- улс төрийн шинжтэй байв. Улсын бүх газар нутаг, хүн ам баруун, зүүн гар, төв хэсэг хэмээн гурван тойрогт хуваагдаж, тойрог бүр дотроо түмэн, мянган, зуун, арван болон задардаг байв. Монголын цэрэг-захиргааны хамгийн бага нэгж нь хаандаа арван нэгж гаргаж өгөх үүрэг бүхий бүлэг айл өрх, хамгийн том нэгж нь хаандаа арван мянган цэрэг гаргаж өгч чадах засаг захиргааны нэгж болох түмт тус тус болж байжээ. Аливаа хэрэг тохиолдвол хаандаа мянган цэрэг гаргаж өгч чадах засаг захирааны нэгж-мянгатад хуваарилж, мянгат бүрт үе залгамжлан эзэмших эзэд- мянгатын ноёд тавигдаж байжээ. Мянгат бол Чингис хааны үед засаг захиргааны үндсэн нэгж бөгөөд түүнээс мянганы ноён хэрэгтэй бүхнээ гаргуулан авч байв. [8] Аравт, зуут гэж хуваасан нь шинэ зүйл биш боловч, харин Чингис хааны төрийн зохион байгуулалт дахь хоорондын үүрэг, эрх мэдлийн тодорхой болгож, цэгцлэн бэхжүүлж чаджээ. Цэрэг засаг захиргааны нэгж бүр хамгийн доод шатнаас эхлэн цэрэг эрсийг унах морь, идэх хоол, зүүх зэр зэвсгийн хамт гаргахаас гадна мөн нилээд төрийн албыг залгуулдаг байжээ. Улс гүрний зохион байгуулалтын ийм уян хатан систем дайн хийх нүүдлийн язгууртны өвөрмөц нөхцөл байдалтай холбогдон буй болсон бөгөөд Чингис хаан дуртай цагтаа үлэмжхэн цэрэг дайчлах бололцоог олгож өгсөн болно [9]. Чингис хаан өөрийн бие хамгаалах цэрэг-хишигтнийг бэхжүүлж тоог нь түм хүргэсэн байна. Хишигтэн нь түүний засаг төрийн гол тулгуур болж байв. Бүх Монгол хүний дотроос шилдэг сайныг нь сонгож хишигтэн болгох бөгөөд өөрөөр

хэлбэл бүх цэргийн шилдэг хэсэг нь болж байжээ. Чухал үед тэд цэрэг захирна. Дээд захиргааны хүмүүсийг гагцхүү хишигтний дотроос томилно. Тэд байлдааны үед хааныг дагаж явна. Тэд хэзээ ч албанаас чөлөөллөгдөх гэж үгүй. Чингис хаан: урьд би наян хэвтүүл манаачтай, жаран шадар хишигтэнтэй байлаа. Одоо мөнх тэнгэрийн өршөөлөөр, тэнгэр газрын ивээлээр хүч их нэмэгдэж, гур их улсын хаан болов. Одоо надад мянган шадар хишигтнийг ялгаж өг. Хэвтүүл, хорчин, торгуудын хамт бүгд түмэн хүн болгож өгтүгэй хэмээн зарлиг буулгажээ [10]. Чингисийн хишигтнүүд төрийн гол үүрэг болох олон нийтийг захирах үүргийг гүйцэтгэж, харьяа ноёд ба энгийн нүүдэлчдийн зүгээс гарах аливаа дургүйцэл, эсэргүүцлийг дарах гол хүч болж байжээ. Хишигтэн нь нүүдлийн язгууртны төлөөлөгчид түмт, мянгат, зуутын ноёдын хөвгүүдээс бүрэлдэж байв. Харин шадар цэрэгт ноёдын хөвгүүдээс гадна сул хүн, харц ардын хөвгүүд дотроос бэлэг эрдэмтэй, бие сайтай, үнэнч шударга хүнийг сонгон авч хэрэглэдэг байжээ.

Цэрэг- захиргааны бүх нэгжийг Чингис хааны ойр шадар нөхрүүд, ноёд толгойлж, тулгуур улсаа бэхжүүлж, хаан эзнийхээ засгийн эрхийг бататгахын төлөө хамаг хүчээ өгч байжээ. Чингис хаан улсаа эмхлэн байгуулахдаа итгэлт ноёдын нэг Барулас овогтны алдарт хүн Хубилайг цэргийн үйл явдлыг ерөнхийлөн захирагчийн тушаалд Боорчи, Мухулай, Наяаг түмний ноёд болгож баруун, зүүн, төвийн түмнийг захируулжээ. Зэв, Сүбээдэй мэт эрэлхэг нөхдөө мянганы ноён болгожээ. Чингис хааны ихэнх нь язгууртнаас гаралтай бөгөөд олон аймгуудаас шилэн сонгож авч байжээ. Жишээ нь: Урианхайн Зэлмэ, Татарын Шихихутаг, Жалайрын Мухуйлай, Тайчуудын Боорчи нар есөн өрлөгт багтаж байжээ. Эдгээр ноёд хаандаа морь, нохой мэт зүтгэж явсан тул улс гүрэндээ их эрх дархтан болжээ. Чингис хаан улс гүрнээ тохинуулахдаа цэрэг-захиргааны зөв системийг зохион байгуулахын тулд аль хэдийнээс уламжлалт нөхрийн ёсыг чадамгай ашигласан байна. Чингис хаан гол гурван түмтэд газар нутгийг заан эзэмшүүлэхийн зэрэгцээгээр зарим мянганы ноёдыг онцгойлон үзэж тусгай нутаг дархлан олгосон явдал бий. Чингис хаан өөрийн нөхөд хэмээх зэвсэгт эрсийн дотроос улс байгуулахад онцгой гавьяа байгуулсан ерэн таван хүнийг нэр цохож мянганы ноёноор өргөмжилжээ. Монголын бүх газар нутаг улсын өмч байсан бөгөөд улсын газрын дээд өмчлөгч нь Чингис хаан байв. Чингис хааны дэргэд сэцдийн зөвлөл гэж байсан бөгөөд хаан аливаа ажил явуулахдаа тэдний зөвлөгөөг анхааран сонсдог байжээ. Хаан сонгох, байлдах, найрамдах зэрэг онцгой чухал асуудлыг “Их хуралдай” гэдэг улсын ихэс ноёдын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж байв. Чингис хааны засаг захиргааны бас нэгэн шинэтгэл бол улсын шүүгчийг бий болгож, тэр үеийн Монголын төрийн нэрт зүтгэлтэн Шихихутагийг төрийн анхны шүүгчээр томилон ажлуулсан явдал мөн. Ордны дотоод хэргийг захирах

зургаан чэрби байсан ба зарц, шивэгчин, хааны сүрэг мал хариулагчдын даамал, тогооч, тэрэгч гэх мэт хааны ордны янз бүрийн албан тушаалын бараа бологчдоос бүрэлдэж байжээ. Хааны мал сүргийг хэвтүүл нар эрхлэн мэдэж байжээ.

XIII зууны үеийн Монголд төрийн алтан тамга, хөх тамга гэж Монгол бичиг бүхий хоёр тамга байжээ. Үүнээс гадна төрийн элчийн авч явдаг алт, мөнгө, хүрэл пайзуудыг хэрэглэж байв.

Эзэн төрийн эрхээр
Эелэж хамт жаргая
Хааны их буянаар
Хамаг улсыг хамтатгая
Хаан эцгийн буянаар
Харгис мууг арилгая
Богд эзний буянаар

Бүхэн улс амрая [11] гэх зэргээр тэр үеэс уламжлан ирсэн төрийн дуулал нь эсэн мэнд амьдрах аж төрөхөд төрийн үүрэг, эзэн хааны ач холбогдлыг ихэд товойлгож байжээ.

Монголын төр нь төр улс энх тайван, найрамдлын бэлгэ тэмдэг, дээр дооргүй харилцан жаргахын бэлгэ тэмдэг мөн хэмээн дүрсэлж, тэрхүү төрийн хэмжээгүй эрхт эзэн хааныг тэнгэрийн ивээлээр энэ дэлхийд энх амгалан тогтоохоор илгээгдсэн тэнгэрлэг язгууртан мөн гэсэн үзэл санааг илэрхийлж байжээ. Бүр Монгол аймгуудыг нэгтгэхийн төлөө тэмцэл ид өрнөж байх үеэс Тэмүүжинд хүчин зүтгэсэн Хорчи өвгөн: Би Жамуха лугаа хэвэл нэгтэй, хэлхээ бэхтэй тул түүнээс хагацаж болохгүй. Гэвч зайран тэнгэр надад үзэгдэн “Тэнгэр газар зөвлөж Тэмүүжинг улсын эзэн болготугай” гэв [12]. Хэрэв Тэмүүжин чи улсын эзэн болвоос намайг хэрхэн жаргуулах вэ? хэмээн асуухад Тэмүүжин: Үнэхээр би улсын эзэн болвоос чамайг түмний ноён болгоё гэжээ. Чингисийг хаан болгосон тухай Хэрэйдийн хаанд хэл өгөхөд тэр: Тэмүүжин хөвгүүнийг минь хаан болгосон нь маш зөв. Монголчууд хаангүй байж яаж болно.

Энэ шийдвэрээ эвдэхгүй
Эв зангиагаа таслахгүй
Эх захаа алдахгүй

Эгнэгт журамтай бай гэсэн хэмээн өгүүлжээ [13]. Мөн Мэнлиг өвгөний хүү Хөхөчү бөө Чингис хааны заяа буян урьдаас тодорхойлогдсон хэмээх үзэл санааг дэлгэрүүлж “Мөнх хөх тэнгэр” Чингис хаан ба түүний алтан ургийг тэтгэн тэнхрүүлж байна хэмээж, хаан өөрөө ч тэнгэр намайг бүх улс орныг захирсугай хэмээн зарлигдсан юм гэж өгүүлж байжээ. Тэрбээр мөнх тэнгэрийн тусламжтайгаар Хэрэйд аймгийг бут цохиж энэхүү их ор сууринд хүрсэн гэж

үзнэ. Түүний есөн хөлт цагаан туганд хааны сүр сүлд агуулагдаж байдаг, тэгэхлээр Монгол цэргийн ялалт бол чухамдаа мөнх тэнгэрийн ивээл мөн гэж үзнэ. Мөнх тэнгэр бол гагцхүү хаан ба түүний алтан урагт энэхүү их хайр ивээлийг хүртээсэн юм хэмээн үзнэ. Иймээс Чингис хаан бол аливаа асуудлаар ард түмэндээ хандаж байсангүй, харин гагцхүү өөрийн алтан ураг, өөрийн хөвгүүд, ноёд, баатрууддаа хандаж байжээ. [14] Монголын хаан бүхний хаан “Тэнгэрийн хүү” гэгдэх болжээ. Чингис хаан тэнгэрийн зарлигаар бүх дэлхийг эзлэн захирах “Мөнх хөх тэнгэр”-ийн үзэл байсан байна.

Хаан хүн чухам ямар үзэл бодолтой хүн байх тухай Чингис хаан удаа дараа өгүүлж байсан хэмээн түүх бичигт тэмдэглэжээ. Үүнд хаан хэмээгч өөрийн зэрэг хэргэмийн адил дураар хэлж үл болох, үнэн хаан хэмээгч хаан хэмээх нэр өргөлгүйгээр аяндаа олны сэтгэл хаан мэт үзнэ. Үүнийг сая хаан гэнэ. Хэрэв хаан болоод хааны явдлыг алдваас хаан болж юу хийх вэ? Эдүгээ та нөхөд надад хэтэрхий нэр зүүх хэмээх нь миний дөрвөн зүгт явахыг халхлах хэрэг болой. [15] Миний баясах нь дэлхий дахин нэгэн гэр бүл төв төвшин, энх амгалан болбоос сая миний баясах хэрэг. Эргэн тойрон ёс бус олон хаад байна. Тэд эрх дураараа аашилж, олон амьтныг зуун зүйлээр зовоож, үргэлж цэрэглэн байлдаж, хүний үхэх нь элс хийсэхтэй адил болжээ. Иймээс би тэднийг нийтээр энх төвшин болгох бодолтой байна. Учир нь нэгэн хүн төрөөд түмэн газрыг энхжүүлэх нь цөм хүн болон төрөгсдийн тусгай явдал мөн бөгөөд хэрэв чадваас дээд тэнгэрт гавъяа ажээ, доод амьтанд өршөөл ажээ хэмээн өгүүлснээс үзэхэд Чингис хаан өөрийн төрийн бодлого, өөрийн төрийн тэргүүн-эзэн хааны зорилтыг дэлхий дахиныг байлдан дагуулах замаар нэгэн гэр бүлд нэгтгэж, бат бэх энх тайван тогтоох явдал мөн гэж үзэж байсан байна. Чингисийг хаан болгосны дараа цэрэг авч гадагш явахыг нөхөд нь хориглоход тэрбээр: хүний хаан хэмээгч газар орны зан амьсгалаар орныг энхжүүлэхийг эрхлэнэ. Өчигдөр сая сууриндаа сууж хаан болмогц улсын хэргийг орхиж, биеийн жаргалыг эрвээс эдүгээд их төрд харш, хойшид үр ач нарт муу суртал болно. Дэлхий дахины ямарваа үйлс зүтгэхээс бүтнэ, алжуугаас бүрдэнэ [16] гэжээ. Тэгээд эрдэм өршөөлт сайн эзэн улсын эзэн, эрх ухаант сайн түшмэл төрийн эрдэнэ, эвэргүү мэргэн сайн эм гэрийн эрдэнэ, элбэрэл тахимдуу сайн хөвгүүн үүрдийн эрдэнэ⁵² хэмээн хэлсэн гэж дэвтэрт бичиж олонд тараан зарлаж сургаал болгожээ. Чингис хаан мөн чийрэг эзэн, чадвартай сайд улсыг байгуулахын эрдэнэ, чанга цааз, цэнгэлт шан цэргийг захирахын сүр, чигч жонон, чадамгай жанжин чанадасыг дийлэхийн үндэс, чанарт илд, чакхимай нум чадалыг мэдэхийн товчоо [17] мөн гэх мэтээр төрд зүтгэгч хаад ноёд,

хатагтай хөвгүүд, баатар жанжнууд болон цэргийн сахилга бат, зэр зэвсгийн ач холбогдлыг өндөрт өргөн тавьжээ.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Чингис хаан суугаад өөрийн төр ёсыг тогтоож, улс байгуулахад хүчин зүтгэсэн нөхөд сайдууддаа нэр цол өргөмжилөн их ёслол хийж бас олон сайд нартаа хандаж: төрд тустай үгс айлтгамуу хэмээн хүсэхэд Боорчи:

Хаан хүний гучин таван эрдмээр хамагт хандаж
Хас төрийн хууль ёсоор хурц чанга тэгштгэж
Хамаг улсын үр ач нарыг хүмүүжүүлэн сургаж
Хамт бүх улс иргэнээ амар энх болтугай хэмээн,

Чуу мэргэн:

Хэмжээгүй өршөөлөөр өнчин бэлэвснийг тэтгэж
Хэмжээт хатуу засгаар ховч бялдуучыг засаглаж
Хэтэрхий их улс төрийг хэв хуулиар засаж

Хэв хэзээд арилашгүй төр ёсыг тогтоомуу [18] хэмээн хариу өгүүлсэн гэж сурвалж бичигт тэмдэглэснээс үзэхэд төр бол нэг талаас шударга өршөөлт байх ба нөгөө талаас харш явдалд хатуу чанга засаглах ёстойг чухалчилж байсан нь тодорхой ажээ.

Уйгурын Идүүд ханд Чингис хаан охиноо өгөхдөө: Хатагтай хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр. Түүний дараах эр нь авсан эр мөн болой. Алтан төрийг хатуужин дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл авсан эр ангид үл одмой [19] хэмээн сургамжилан захижээ. Мөн Чингис хаан Ибага бэхи хатандаа:

Авир зангийн чинь голсон биш
Ариун үзэсгээлэнгий чинь чамалсан биш
Өврөөрөө дулаацуулж
Хөлөө хучуулсан
Өөрийн хатан чамайг
Их төрийн үйлсэд
Илт зүтгэсэн Жорчидайд
Ийнхүү соёрхох болов.
Хатгалдах цагт
Халх болж
Хагацсан улсыг
Хамтатган өгч
Хатгалдан байлдахад
Хуяг болж
Хуваасан улсыг

Хурааж өгсөн Жорчидайн ачийг хариулж гавъяаг тэмдэглэхийн тулд чамайг өгөв [20] гэж өгүүлсэн хэмээн тэмдэглэснээс үзэхэд эмэгтэй хүн нийгмийн гишүүний хувьд төрийн үйлсэд идэвхтэй зүтгэх ёстой, төр бол түүний амьдралын нэн тэргүүний зорилт мөн гэдгийг товойлгон тавьж өөрийн хатныг хүртэл төрийн чухал үйлсэд зориулах болсон нь төрийн үүрэг ач холбогдлыг маш өндөрт өргөж байсныг басхүү нотлон харуулж байна. Сурвалж бичгүүдэд өгүүлснээр Чингис хаан: Би арван гурван наснаас цэрэг байгуулж эдүгээ жаран зургаан нас хүртэл явж таван өнгө дөрвөн харь улсын цөм олж алба бариулав.

Хас чулуунд хальсгүй
Хайран биед мөнхгүй
Хатуу төмөр ч зэвэрч орхино
Хамгийн эзэн ч үхэж халина
Түмэн үйлсэд үзүүргүй
Төрсөн биед мөнхгүй
Төр улс ч ээлжлэн хална
Түшмэд сайдууд хичээн зүтгэгтүн
Хотод улсыг хичнээн хамгаалж
Хортон мууг сайтар зас
Энэ бие хэврэг боловч
Эрхэм нэр мөнх шүү
Саруул ухаанаас илүү
Сайн нөхөр байдаггүй
Мунхаг хилэнгээс илүү
Муу дайсан байдаггүй
Эрхэм итгэл олон боловч
Энэ бие бүгдээс итгэлтэй
Хайрлах юм олон боловч
Халуун амийг хамгаас хайрлалтай
Хатуужиж явбал хамагт хэрэгтэй

Ариун явбал ашид тустай [21] хэмээн удаа дараа сурган захиж байсан бөгөөд атга хүчээ ихэтгэе гэвэл цэргээ асар, уудам сул жаргая гэвэл эв эеэ хичээ, харин газар арга чадлаа бэхэл, халуун зуураа эв эеэ хичээ [22] хэмээн нэр төр, эв нэгдлээ хичээн эрхэмлэх санааг чухалчилж байжээ. Чингисийн билигт” дурдсанаас Чингис хаан дөрвөн хөвгүүнээсээ зол жаргалын дээд юу вэ? гэж асуухад хөвгүүд нь янз бүрээр хариулжээ. Харин Өгэдэй хүү нь: Надад ухваас суут хаан эцгийн зовон зөөсөн их улсыг амруулан хөл хөсөр, гар газар тавиулж улс иргэнээ уртад агуулж төр ёсоо түвшин барьж, өтгөс ихэсийг

жаргуулж, өсөх залуусыг амруулваас жаргалын сайн энэ юм [23] гэж өчихөд Чингис хаан: Өгэдэй маш зөв гээд :

Аль бие минь алжааваас алжаатугай

Ахуй төр минь бүү алдартугай

Бүтэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү задартугай[24] гэж ерөөжээ.

Энэ бүхэнд Чингис хаан төр ёсны үзлийн чухал талууд, тухайлбал өөрийн байгуулсан төр улсыг хайрлан хамгаалж, хадгалан бэхжүүлж, түүний төлөө эр, эм бүх хүмүүс амьдрал үйлсээ зориулахын учир холбогдлыг үр ач нартаа сургамжлан захисан санаанууд илэрч байгаа ажээ.

Зохион байгуулалтын бүтцийг өмнөх төрүүдээс улам нарийсгаж, хууль цаазыг буй болгон мөрдүүлж, үлгэр жишээ болохуйц цэрэг арми байгуулан бэхжүүлж, хатуу чанга сахилга бат тогтоож, төрийг байнга хайрлан бэхжүүлэхийн чухлыг бүх талаар үндэслэсэн Чингис хааны төр ёсны үзэл нь тэр үеийн Монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний болон улс төрийн сургаалын чухал ололтын нэг болж байжээ. Төрт ёсонд холбогдох сургаал, асуудалд нухацтай олон талаас нь шүүн үзэх нь чухал юм.

ДҮГНЭЛТ

Чингис хаан төр ёсны үзлийн чухал талууд, тухайлбал өөрийн байгуулсан төр улсыг хайрлан хамгаалж, хадгалан бэхжүүлж, тогтвортой төр засаглалыг бэхжүүлэх олон арга хэмжээнүүдийг хэрэглэж байсан байна. Түүний нэг чухал илрэл бол хүрээлэл, нөхөрлөл андын харилцааг бий болгох, шударга ёсыг тогтоохын төлөө тэмцэж ирсэн байдаг.

Төрийн хариуцлагатай тогтолцоо, хууль цаазыг буй болгон мөрдүүлж, үлгэр жишээ болохуйц цэрэг арми байгуулан бэхжүүлж, хатуу чанга сахилга бат тогтоож, төрийг байнга хайрлан бэхжүүлэхийн чухлыг бүх талаар үндэслэсэн Чингис хааны төр ёсны үзэл нь тэр үеийн Монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний болон улс төрийн сургаалын чухал ололтын нэг болж байжээ.

НОМ ЗҮЙ

- [1] Алтан товч. (Лувсанданзан). УБ., 1990 он
- [2] БНМАУ-ын түүх, Гурван боть, Тэргүүн боть, нэн эртнээс XVIII зуун, УБ., 1966
- [3] Батсуурь Ж. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгөсөн нь, Дорно дахины судлалын асуудал. УБ., 1988 он, №1
- [4] Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой, УБ., 1959
- [5] Жамбал А. Улс төрийн сургаалийн түүх. (Эртний үе) I-дэвтэр. УБ. 2001
- [6] Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ УБ., 2002
- [7] Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ. 2003
- [8] Монголын нууц товчоо. УБ., 1976, 1990
- [9] Монголын философийн түүх. I дэвтэр. УБ. 1997

- [10] Монгол Татаарууд Ази, Европт /эмхэтгэл/ УБ.,1984
- [11] Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал. Хянан тохиолдуулсан профессор, доктор Н.Лүндэндорж. УБ. 2002
- [12] Цэрэнсодном Д. Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Ред Д.Төмөртоогоо. УБ., 2000